

Төсвийн зарцуулалтыг хэмнэлтийн горимд шилжүүлж санхүүгийн сахилга батыг сайжруулах

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж 2023 оны 05 сарын 31-ны байдлаар нийт 278151.6 мянган төгрөг батлагдсан ба үүнээс 191427.6 мянган төгрөгийг зарцуулан төсвийн 86724.0 мянган төгрөг буюу 31.1 хувиар хэмнэн ажилласан байна.

Дотоод аудит –Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2023 оны А/157 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу байгууллагын 2022 он болон 2023 оны 05 дугаар сар хүртэлх хугацааны санхүүгийн үйл ажиллагааг дотоод аудитад хамруулсан. Ирсэн зөвөлгөө, зөвлөмж ирээгүй байна.

Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухай жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл-

2022 онд 424,843.2 мянган төгрөг батлагдан 392,822.7 мянган төгрөгийн төсвийн гүйцэтгэлтэй зарцуулагдсан. 2023 онд нийт батлагдсан төсөв 574,238.1 мянган төгрөг үүнээс 06 дугаар сарын байдлаар 314,810.0 мянган төгрөг батлагдаж 235,490.6 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна. 2024 оны төсвийн төсөөлөлийг 2023 оны 06 дугаар сарын байдлаар явуулаагүй байна.

хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;

Байгууллагад хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр хураамж байхгүй болно.